



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 467

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3 дахь заалтад дор дурдсан нэмэлт оруулсугай.

1.1.“Төсөвт байгууллагын дансанд бүртгэлтэй, төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийн дуудлагын худалдаанаас олсон орлогоос тухайн дуудлагын худалдааг зохион байгуулахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтсугай.” гэсэн 3 дахь заалтын “зардлыг” гэснийг “зардал (хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн бол үнэлгээний төлбөр, дуудлагын худалдааны зар мэдээ байршуулахад төлсөн төлбөр)-ыг” гэж;

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

2.1:Дуудлагын худалдаагаар худалдах төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийн худалдаагаар санал болгох доод үнэ 1,000,000.00 (нэг сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 100,000.00 (нэг зуун мянган) төгрөгөөр, 1,000,001.00 (нэг сая нэг) төгрөгөөс 5,000,000.00 (таван сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 500,000.00 (таван зуун мянган) төгрөг, 5,000,001.00 (таван сая нэг) төгрөгөөс 10,000,000.00 (арван сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 1,000,000.00 (нэг сая) төгрөг, 10,000,001.00 (арван сая нэг) төгрөгөөс дээш бол үнэ хаялцах доод хязгаар 2,000,000.00 (хоёр сая) төгрөгөөр тус тус тогтоосугай.

3.Энэхүү тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг орон нутгийн өмчийн харилцаанд жишиг болгож, холбогдох дүрэм, журамдаа өөрчлөлт оруулан мөрдөж ашиглахыг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

5.Тогтоолыг нийт төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга (Д.Нарангэрэл), Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Дэлгэрмаа) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ДЭЛГЭРМАА



D. Delgermaa